

**2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 02 дугаар сарын 07-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. **Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.**

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС 2024 ОНЫГ “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН</b>		
1	2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдах “Нийслэл Улаанбаатар хот-Хөгжлийн бүс” форумын урьдчилсан хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ЗДТГ, БҮТП
2	Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллах.	ЗДТГ, нийт байгууллагууд
<b>НИЙСЛЭЛЭЭС 2024 ОНЫГ “ТОХИЖИЛТ-БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН</b>		
3	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласан тул хэрэгжилтийг хангаж ажиллах.	ТХҮХ
4	2024 онд Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын бэлтгэлийг сайтар хангах. Үүнд: -Эрх шилжүүлж дуусгах. -Үнэлгээний хороог шуурхай байгуулах; -Худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулах; -Газар чөлөөлөлтийн ажлыг үе шаттайгаар эрчимжүүлэх. -3 дугаар сарын 1-ээс эхлэн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх.	ЗДО Б.Болормаа, ХААА
5	2024 оны нийслэлийн төсвийн орлогын хуваарь батлагдсантай холбогдуулан байгууллагууд оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бааз суурийг өргөтгөх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллах.	ЗДО Б.Болормаа, СТСХ, Татварын хэлтэс
<b>БУСАД ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД</b>		
6	Нийслэлд газар олголт, хот тохижилтын машин техникийн худалдан авалтын талаар нээлттэй сонсгол зохион байгуулагдах тул дүүргээс холбогдох мэдээллийг хүргүүлэх бэлтгэл ажлыг хангах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ, ГЗБА
7	Ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхэлсэнтэй холбогдуулан дараах ажлуудыг зохион байгуулах. Үүнд: 1.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн хамрагдалтын тоон, мэдээлэл гаргах; 2.Салбарын хөрөнгө оруулалтын ажлын явцыг гаргах; 3.Сургууль, цэцэрлэггүй хороодын мэдээлэл, судалгааг гаргах; 4.Сургууль, цэцэрлэгийн орчмын цас мөсийг цэвэрлэж, халтиргаагүй болгох;	Боловсролын хэлтэс, Холбогдох ажлын хэсэг

	5.Биеийн тамирын заал, тоглоомын талбайд үзлэг хийж, аюулгүй нөхцлийг бүрдүүлэх; 6.Ил задгай цахилгааны утас байгаа эсэхийг шалгаж, хүүхэд хүрэх эрсдэлгүй болгох; 7.Ухсан нүх, шуудуу, траншей болон замын эвдрэлийг таглаж битүүлэх; 8.Замын нөхцөл байдал, замын тэмдэг тэмдэглэгээг шалгах, засварлах; 9."School police" хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх; 10.Лед гэрлэн гарц суурилуулах ажлыг эрчимжүүлэх;	
8	Дүүргийн хэмжээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гамшиг осол гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулах, шинэчлэх.	ОБХ
9	Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, ус, дулаан, цахилгаан хангамжаар байгууллага, иргэдийг тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлж ажиллах.	ТХҮХ, Инженерийн дэд бүтцийн байгууллагууд УСАТ, Илч-Орд ОНӨААТҮГ, БОС, Эрчим хүч, ус хангамжийн ангиуд
10	Нийтийн эзэмшлийн гудамж талбай болон гэр хорооллын өгсүүр гудамж, зам талбайн цас, мөсийг цэвэрлүүлж, халтиргаа гулгаа арилгах, хог хаягдлуудыг цэвэрлэх, тээвэрлэх ажлыг зохион байгуулж, хотын гудамж, талбайн гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд, Хороод
11	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд газар дээр нь явж ажиллах.	ТХҮХ, ОБХ
12	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, иргэд, олон нийтээс ирүүлж буй гомдол мэдээллийг судалж холбогдох арга хэмжээг авч ажиллах.	ЦХ-ийн Замын Цагдаагийн хэсэг
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
13	Дүүргийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах.	НХХ, ЭМТ, Хороод
14	УБЗАА-наас Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн цэвэрлэгээний болзолт уралдаан зарласантай холбогдуулан дүүргийн Засаг даргын захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй хамрагдах.	ТХҮХ, Хороод, ААНБ-ууд
15	2024.02.01-ний өдөр (Пүрэв) олон улсад зарлагдаж буй тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах талаар ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгуулагдах тул бэлтгэлийг сайтар ханган сургалтын байгууллагатай хамтран ажиллах.	Боловсролын хэлтэс, ХЦС, Соёлын ордон
16	Нийслэлийн хот тохижилтын газраас гинжит бульдозер авах талаар ярилцсан тул тус байгууллагад хандан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
17	Сар шинийн баярын үеэр ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг гаргаж томилгоожуулах.	ОБХ
18	Соёлын ордны дэд бүтэц татах ажлын хүрээнд техникийн нөхцөл олгохдоо тооцоолол гаргах. (Халаалтын зуухыг	Илч-Орд ОНӨААТҮГ

	урагшаа гаргавал буцаж дэд бүтэц татах план зураг гаргах ажлыг яаралтай гүйцэтгэх)	
19	МАН эрхлэхийг хориглосон бүсэд авах арга хэмжээг эрчимжүүлэх, замын Цагдаагийн постны дэргэдэх журмын хашааг ашиглалтад оруулах талаар нөхцөл боломжийг судалж танилцуулах.	ЗДО Б.Болормаа, ТЗУХ, Цагдаагийн хэлтэс

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР